



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 51 02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025-12-25 № 01/2955
танай _____-ны № _____-т

“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТУГ-Т

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх журам”-д заасны дагуу танай “2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хянаж, 95.98 хувьтай үнэлэн тайлангийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлантай танилцаж, дүгнэлт зөвлөмжийг 2026 онд хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 9.. хуудастай.

Э. БАТШУГАР

1525073285



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТУГ-ЫН 2025 ОНЫ СҮҮЛИЙН
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТУГ-ЫН 2025 ОНЫ СҮҮЛИЙН
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025 оны 12 сарын 23-ны өдөр

№...

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Үндэсний дата төв” УТУГ-ын төлөвлөгөөнд туссан 66 арга хэмжээний 2025 оны сүүлийн хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2025 оны жилийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын үнэлгээний арга зүй болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

$$\text{Төлөвлөгөөний хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилгот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100\%$$

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

“Үндэсний дата төв” УТУГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 66 арга хэмжээний биелэлтийг 2025 оны 12 сарын 23-ны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн биелэлттэй - 52
2. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-90%-ийн гүйцэтгэлтэй - 14

Үнэлгээ хийгдсэн арга хэмжээний дунджаас үзвэл байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.98 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна гэж үнэлэгдлээ.

“Үндэсний дата төв” УТУГ нь Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэх зорилго бүхий Цахим монгол, Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 183 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд тус газрын төлөвлөсөн 66 арга хэмжээнээс амжилттай хэрэгжиж буй дараах арга хэмжээнүүд байна гэж үзлээ. Үүнд:

Төлөвлөгөөний 1.1.4-т Дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд Дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор өдөр тутмын үзлэг, хяналтын ажлуудыг төлөвлөгөөт ажлын дагуу тогтмол хийж гүйцэтгэсэн байна. Үүнд ✓ Үндсэн болон нөөц төвийн дэд бүтцийн системд 416 удаагийн үзлэг, үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Ашиглалтын 11 ширхэг техник тоног төхөөрөмжийн паспортыг долоо хоног бүр шинэчлэн хөтөлж, үзлэгээр илэрсэн нийт 32 төрлийн гэмтэл, доголдлыг шуурхай арилгаж, төвийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангасан;

- ✓ Барилга байгууламжийн тодорхой хэсгүүдэд гэрэлтүүлгийн ашиглалтыг сайжруулах судалгаа хийж, фото реле суурилуулж байгалийн гэрэл хангалттай үед гэрэлтүүлэг автоматаар унтрах нөхцөлийг бүрдүүлсэн;
- ✓ Үндсэн болон нөөц төвийн хэмжээнд оффисын болон хөргөлтийн төхөөрөмжүүдийн цахилгааны хэрэглээг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх судалгаа хийсэн;
- ✓ Шаардлагатай фреон, чийгшүүлэгчийн тогоо зэрэг хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлж, тасралтгүй үйл ажиллагааг хангасан;
- ✓ Үндсэн болон нөөц төвийн дэд бүтцийн тоног төхөөрөмжүүдийг нэгдсэн хяналтын системд нэгтгэх судалгаа, туршилтын ажлыг эхлүүлж, нэгдсэн хяналтад оруулах боломжтой тоног төхөөрөмжүүдийн өгөгдлийн мэдээллийг бүрдүүлэн ажилласан гэжээ.

Төлөвлөгөөний 2.1.2-т Төрийн цахим шуудангийн системийг төлөвлөгөөний дагуу 10.0.6 хувилбараас 10.1.7 хувилбарт шилжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба шинэчлэлийг хийснээр 65 эмзэг байдал засагдсан бөгөөд үүнээс 40 CVE-ээр бүртгэгдсэн 25 CVE-гүй/TBD байна;

- ✓ Хагас жилийн хугацаанд тус системд нийт 4 удаа доголдол үүссэн ба үүнээс 1 удаа хадгалах төхөөрөмжийн саатлаас 3 удаа программ хангамжийн асуудлаас үүдэлтэй доголдол үүссэн;

- ✓ Төрийн 727 байгууллагын 1,055 домайнаар 64,412 төрийн албан хаагчдад төрийн цахим шуудангийн үйлчилгээ үзүүлсэн байна

Төлөвлөгөөний 2.3.1-т Үндсэн болон дэмжих системтэй холбоотой 4,457 хүсэлт хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Хамгийн ихээр давтагддаг, нийтлэг үүсдэг хүсэлтийг шийдвэрлэхээр шифрлэлтийн гарын авлага, видео контентыг бэлтгэн "guide.datacenter.gov.mn"-д байршуулсан;

- ✓ Үндсэн болон дэмжих системийн Цахим гэрээний "Geree.gov.mn" системээр тайлант хугацаанд нийт 571 гэрээг байгуулснаас ХУР системд холбогдох үндсэн болон нэмэлт нийт 416, ДАН системд холбогдох үндсэн болон нэмэлт нийт 155 гэрээг байгуулсан;

- ✓ Тайлант хугацаанд нийт Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ирсэн 35 албан тоот, цахим шуудангаар ирүүлсэн 4,842 хүсэлтийг тус тус шийдвэрлэж харилцагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажилласан;

- ✓ Эрүүл мэндийн салбарын систем хөгжүүлэгч байгууллага (МИТПС ХХК, Клиник ХХК, Метронэтворкс ХХК, Аксис системс ХХК, Вингс Пос ХХК, Дижитал Андмед ХХК, Маргад Онс ХХК)-уудыг ЦХИХХЯ-аас ирсэн 03/436 дугаартай баримт бичгийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Үндсэн систем "ХУР"-ыг төлбөргүй ашиглах тохиргоо хийсэн байна

Төлөвлөгөөний 2.3.4-т Танилт, нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" системийн 2.0 хувилбар болон Цахим гэрээний "geree.gov.mn" системийн хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулж, байгууллагын гарын авлагын "guide.datacenter.gov.mn" цахим систем болон "geree.gov.mn" системд байршуулсан. Энэхүү цахим гарын авлагад Цахим гэрээ (geree.gov.mn), ХУР, Домэйн, Зохиомол сервер, ДАН, Төрийн байгууллагын цахим хуудас, Цахим хуудас, Төлбөрийн биллинг систем, Төрийн цахим шуудан зэрэг үйлчилгээнүүдийн заавар, гарын авлагыг нэгтгэн байршуулсан бөгөөд ирж буй хүсэлтүүдийг бууруулах зорилгоор хэрэглэгчдийг гарын авлагын систем рүү чиглүүлэн ажилласан;

- ✓ VMWare суурьтай vcsa.gov.mn дээр нийт 858 систем ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 01 дүгээр сараас шинээр ирүүлж буй системүүдийг "Mcloud" системд байршуулан ажиллаж, нийт 168 зохиомол сервер шинээр үүссэн. "Mcloud"-г төрийн нэгдсэн сүлжээнд оруулснаар зохиомол серверийн дэд бүтцээс системүүдийг шилжүүлэх боломж бүрдэж, төрийн нэгдсэн сүлжээнд оруулах бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөний 2.6.1-т Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Интернэтийн харилцан холболтыг сайжруулах ажлын дагуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг хүлээн авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу АТС32 (Төв шуудан) байрлалд 2 ширхэг, АТС45 (Жуков) байрлалд 1 ширхэг төхөөрөмжийг суурилуулж, High Availability (HA) орчин

бүрдүүлэн ажиллагаанд оруулсан. Уг ажлын үр дүнд Интернэтийн харилцан холболт Layer2 технологийн түвшинд шилжин, нийт 40 байгууллага холбогдон ажиллах техникийн боломжийг бүрдүүлсэн. Мөн АТС45 буюу МХС-ийн Жуков салбарт нөөц төхөөрөмжийг байршуулах замаар газарзүйн хувьд бие даасан, тасралтгүй ажиллагааг хангах нөөцлөлтийн нөхцөл бүрдүүлж интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд тус төхөөрөмж рүү холбогдох хүсэлт гарган холбогдох бүрэн боломжтой болсон байна.

✓ Үндэсний дата төвийн олон улсын интернэтийн гарцыг сайжруулах хүрээнд дундын төхөөрөмжөөр дамжуулах шаардлагагүй, шууд “Жемнэт” ХХК-ийн холболт хийж үндсэн сүлжээний архитектурт шинэчлэлт хийж хэрэгжүүлснээр дундын төхөөрөмжийн боломжит гэмтэл, тасалдлын нөлөөллөөс ангид, найдвартай, тасралтгүй интернэтийн гадаад гарцтай болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дээрх ажлуудаас гадна нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд болон нийтийн мэдээллийн дэд бүтцэд суурилсан үйлчилгээг хүний нөөцийн тогтвортой хөгжил, удирдлага зохион байгуулалтын хүрээнд хүргэх олон ажил арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна.

Гэсэн хэдий ч үр дүн муутай, дутуу хэрэгжүүлсэн, санхүүжилтийн шатанд зогссон 70 хувиар үнэлгээ хийгдсэн 3 арга хэмжээнээс дурдах нь зүйтэй байна. Үүнд:

Төлөвлөгөөний 2.7.2-т зааснаар Төрийн байгууллагуудад эх кодын хувилбар удирдах систем “GITLAB”-ийн үйлчилгээг үзүүлэх тендерийн ХАА-ны бичиг баримтыг боловсруулан ЦХИХХЯ-нд хүргүүлсэн бөгөөд тендер 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр үр дүн гарсан боловч тендерийн санхүүжилт нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийн олголт хийгдээгүй тул ЦХИХХЯ-аас гэрээ хийгдэж худалдан авах ажиллагаа явагдахгүй тухай мэдэгдсэн учраас арга хэмжээ хэрэгжээгүй гэж үзэж байна.

Төлөвлөгөөний 3.1.4-т зааснаар Сүлжээний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн болон төвийн дэд сүлжээний холболтыг SDN рүү шилжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээс:

✓ Сүлжээний уламжлалт архитектур болон хэрэглэгч төвийн физик тоног төхөөрөмжийн түвшний тусгаарлалтыг АСI технологийн шийдлээр шинэчлэх ажлыг “Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерийн техникийн шаардлагад тусгасан НА Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан. ШӨХТГ, Сангийн яаманд тендерт оролцогч байгууллагаас гомдол гаргаснаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 13 дугаар зүйлийн 13.1.1-д багтан санхүүжилтийн олголт хийгдээгүй тул ажлыг бүрэн хэрэгжсэн гэж үзэх боломжгүй байна.

Төлөвлөгөөний 4.4.1-т зааснаар Салбарын хэмжээнд боловсруулагдаж буй хууль, эрх зүй, бодлогын баримт бичигт санал өгөх ажилд хангалтгүй ажиллаж салбарын хууль, эрх зүйн бодлогын баримт бичигт санал өгөх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Энэ мэтчилэн санхүүжилтийн асуудлаас үүдэн хэрэгжээгүй ажлууд байгаа тул төлөвлөгөө гаргахдаа оны эхэнд санхүүжилттэй ажлуудаа төлөвлөх, төлөвлөгөө бүрийн суурь түвшин, зорилтот түвшинд тавьсан тооны агуулга ойлгомжгүй, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, тайланд хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн хувийг тавиагүй гэх мэт асуудлууд байна.

Иймд Үндэсний дата төв УТҮГ-ын тайлантай холбоотойгоор дараах дүгнэлтийг гаргаж байна.

Дээр бичигдсэн үнэлгээний үр дүнг доор хүснэгтээр илэрхийлэв. Үүнд:

№	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 стратеги	Арга хэмжээ ний тоо	Үнэлгээ
---	---	---------------------	---------

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 1. ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОНО			
1	Арга хэмжээ 1.1.1 UPS төхөөрөмжийг шинээр суурилуулах, холболтуудыг хийж гүйцэтгэх	1	80%
2	Төвийн дизель генераторын байгууламжийг шинэчлэн, сайжруулах	1	80%
3	UPS өрөөний агаарын хөргөлт чийгшил тогтворжуулах систем, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх	1	80%
4	Дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах	1	100%
5	Барилга байгууламжийн урсгал засвар, гадна тохижилтын засварыг хийж гүйцэтгэх	1	100%
6	Төвийн барилга байгууламж, техник тоног төхөөрөмжүүдэд өдөр тутмын үзлэг хийж тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах.	1	100%
7	Техник төхөөрөмжүүдийн ажиллагаанд хэвийн бус горим илэрсэн, доголдол гарсан төхөөрөмжүүдийг шуурхай хэвийн ажиллагаанд оруулах	1	100%
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ ТАСРАЛТГҮЙ НАЙДВАРТАЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭРТЭЙ БОЛОХ			
8	Төвийн систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглагдаж буй сервер тоног төхөөрөмж, системийн үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	1	100%
9	Төрийн байгууллагын цахим шуудангийн системийн ажиллагааг сайжруулах	1	90%
10	Байгууллагын мэдээллийн технологийн программ хангамжуудын лицензийг сунгуулах	1	100%
11	Төвийн хэмжээнд нөөцлөлтийг холбогдох журмын хүрээнд бүрэн гүйцэтгэх	1	100%
12	Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөхөд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах	1	80%
13	Үндэсний дата төв дээр байрших төрийн байгууллагуудын системүүдийг IPv6, IPv4 хос технологи руу шилжүүлэх	1	100%
14	Төрийн mCloud системийн дэд бүтцийг өргөтгөх, "Mindgolia" программ хангамжийн их дэлгүүрийн бүтээгдэхүүнийг төрийн үүлэн тооцооллын "mCloud" системд нэгтгэх, системийг НА редундант байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	1	80%
15	Үйлчилгээний талаарх мэдээллийг гаргах, нэгдсэн мэдээллийн системийг ашиглалтад бүрэн оруулах, тухай бүр шинэчлэх	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
16	Төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах	1	90%
17	Монгол Улсад дата серверийн эдийн засгийн хөгжлийг стратегийн түвшинд дэмжих, бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар манлайлан оролцох, энэ салбарын тэргүүлэгч байгууллага болох	1	90%
18	Мэдээллийн аюулгүй байдал, системийн уялдаа холбоог хангах үндэсний өгөгдөл солилцооны платформ хөгжүүлэхэд мэргэжлийн оролцоог хангаж, технологийн загварчлал, бодлогын зөвлөмж, шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах.	1	80%
19	Олон улсын шилдэг туршлага, технологийг нутагшуулах, хамтарсан төсөл, хөрөнгө оруулалтыг татах замаар гадаад хамтын ажиллагааг стратегийн түвшинд өргөжүүлэн хөгжүүлэх.	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
20	Төрийн болон хувийн байгууллагуудад үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх	1	100%
21	Танилт, нэвтрэлтийн системийг шинэчлэх, үндэсний баталгаажуулагч аппликейшнийг бий болгох	1	100%

22	Хэрэглэгчийн дуудлага хүлээн авах "Callcenter"-ийн зохион байгуулалтыг сайжруулах	1	100%
23	Хэрэглэгчийн үйлчилгээ болон дотоод системүүдийн гарын авлагын систем нэвтрүүлэх	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
24	Үндэсний цахим шуудангийн системийн дэд бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	1	100%
25	Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, машин сургалтын дэд бүтцийг бий болгох бэлтгэл ажлыг хангах	1	80%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
26	Байгууллагын үйлчилгээ үзүүлэх системийг автоматжуулах	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
27	Монголын интернэтийн харилцан холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах.	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА			
28	Толин серверүүдийн аюулгүй байдал болон мэдээллийг тогтмол сайжруулах	1	100%
29	Цахим системийн эх кодыг аюулгүй, найдвартай хадгалж, тасралтгүй нэгтгэх, түгээх, хөгжүүлэх, эх кодын аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн дэд бүтцийг бий болгож төрийн байгууллагуудад эх кодын хувилбар удирдах систем "GITLAB" -ийн үйлчилгээг үзүүлэх	1	70%
30	Дотоодын хэрэглэгчдэд зориулсан нийтийн "Docker image registry" хадгалалтын үйлчилгээг бий болгох	1	100%
31	Байгууллагын үйлчилгээнд ашиглагдах "агуулга хүргэх сүлжээ" /CDN/ серверийг бий болгох	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ			
32	Төвийн гал болон нэвтрэлтийн системийн найдвартай ажиллагааг хангах	1	100%
	Төвийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах ачаалал, ажиллагааны туршилтыг тогтмол зохион байгуулах	1	100%
33	Төвийн систем, цахим шуудан, цахим хуудсанд хийгдсэн мэдээллийн аюулгүй байдлын шалгалтын дагуу эмзэг байдлуудыг арилгах	1	100%
34	Сүлжээний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн болон төвийн дэд сүлжээний холболтыг SDN рүү шилжүүлэх;	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ			
35	Төрийн байгууллагуудын цахим шуудангийн системийн аюулгүй байдлыг хангах	1	70%
36	Төрийн байгууллагуудын цахим хуудасны аюулгүй байдлыг хангах	1	100%
37	Төвийн систем, сүлжээний төхөөрөмжүүд рүү хандах хандалтын хяналтыг сайжруулах, хязгаарлах	1	100%
38	Үндсэн болон дэмжих системийн аюулгүй байдлыг сайжруулах	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ			
39	Төвийн системийн найдвартай, тасралтгүй байдлыг хянах, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах, лог бүртгэлийн нэгдсэн системээр хяналт хийх	1	95%
40	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах	1	100%
41	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлыг аудит хийлгэх Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.5, 19.2.6	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ			

42	Арга хэмжээ 12.1. Хотын бүх салбар, нэгжүүд болон орон нутгийн 5 салбарт хяналт-шинжилгээ, үнэлгээ шалгалтыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана.	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4 НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ			
43	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001 стандартыг магадлан баталгаажуулах Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.3	1	100%
44	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу удирдах дээд байгууллагад хүргүүлэх МУЗГ-ын 2020 оны 217 дугаар тогтоол, журам	2	100%
45	Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх	1	100%
46	Төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	1	100%
47	"Хүний нөөцийн бодлого"-ыг хэрэгжүүлэх, технологийн мэргэжилтний нөөцийг бэлтгэх		100%
48	"Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах	1	100%
49	Худалдан авах үйл ажиллагааг төлөвлөж, удирдах дээд байгууллагад тайлагнах	1	100%
50	Төвийн санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, жилийн тайлан балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх	1	100%
51	Дата төвийн цаашдын үйл ажиллагаа, технологийн дэвшлийг хангах зорилгоор мэргэжлийн, өндөр ур чадвартай хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4 НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ			
52	"Гадаад хамтын ажиллагаа, гадаад арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулж хэрэгжүүлэх		100%
53	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд Төрийн клауд системийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт, зохион байгуулах		100%
54	Удирдах дээд байгууллагуудаас байгуулагдаж буй ажлын хэсгүүдэд хамрагдах хэлбэрээр хамтран ажиллах		100%
55	Төрийн байгууллагуудад үйл ажиллагаа, үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх		100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4 НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ			
56	Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлан төлөвлөгөө хэрэгжүүлэх	1	100%
57	Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	1	100%
58	Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	1	100%
59	"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах	1	100%
60	Засгийн газар, яамд, агентлагаас батлах дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг бий болгох	1	100%
61	Засгийн газар, яам, агентлагаас батлах дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын	1	100%

	оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг ажиллуулах журмыг боловсруулж, батлуулах		
62	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	1	100%
63	Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	1	100%
64	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	1	100%
65	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	1	100%
ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4 НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗӨХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ			
66	Салбарын хэмжээнд боловсруулагдаж буй хууль, эрх зүй, бодлогын баримт бичигт санал өгөх	1	70%
Нийт үнэлгээний дундаж		33	95.98%

Дээрх төлөвлөгөөний арга хэмжээ тус бүрийг үнэлсэн үнэлгээ тус бүрээр ялгаж үзвэл:

1. 70 хувийн биелэлтэй 3 арга хэмжээ
2. 80 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ
3. 90-95 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ
4. 100 хувийн биелэлттэй 52 арга хэмжээ тус тус байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

“Үндэсний дата төв” УТҮГ-ын төлөвлөгөөний хугацааг хэт ерөнхий тавьснаас үүдэлтэй нийт ажлын биелэлт эхний хагас жилд гүйцэтгэл тодорхойгүй байсан ч жилийн эцсийн тайлангаар арга хэмжээнүүд үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Гэвч төлөвлөлт, тайлагналттай холбоотой хэд хэдэн асуудлууд байна. Тухайлбал Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1-д:

“шалгуур үзүүлэлт” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг;

“суурь түвшин” гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

“зорилтот түвшин” гэж тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг ойлгоно гэж заасан.

Тус газрын хувьд шалгуур үзүүлэлтийг тоогоор илэрхийлсэн атлаа чанарын үзүүлэлтийг бас хэмжүүлэхээр тооцсон нь сайшаалттай боловч, тавьсан шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, зарим арга хэмжээний хэрэгжилт хэт товч, зарим арга хэмжээний хэрэгжилт хэт дэлгэрэнгүй буюу 2000 тэмдэгтээс хэтэрсэн, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх эерэг үр дүнг тодорхой дурдаагүй, тайланд гүйцэтгэлийн хувийг тавиагүй гэх мэт асуудлууд байна.

Түүнчлэн төлөвлөлтийн хувьд чухал томоохон арга хэмжээнүүдэд ач холбогдол өгч ажиллах нь зүйтэй байна. Тодруулбал “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2025 оны төлөвлөгөөний сүүлийн хагас жилийн биелэлт 90-аас дээш хувьтай хэрэгжиж байгаа боловч, тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна яамны бодлого хэрэгжүүлэх хүрээнд нэн чухал ажлуудыг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Иймээс цаашид төлөвлөгөө, тайлан болон арга хэмжээг идэвхжүүлж ажиллахтай холбоотой дараах зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Тайлангийн чанар, нотолгоог сайжруулах. Арга хэмжээ бүрийн тайлбар, шалтгаан, үр нөлөөг баримтаар баталгаажуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хялбар, нэгдмэл бүтэцтэй тайлагнах.

2. Шалгуур үзүүлэлтүүдийг арга зүйд нийцүүлэн тодорхойлох. Суурь болон зорилтот түвшнийг үр дүнгийн хувьд бодитой, хэмжигдэхүйц, тайлбар бүхий байдлаар төлөвлөх.

3. Төлөвлөгөөний хугацааг бодитой төлөвлөх. Хүрэх боломжит зорилтуудыг тусгаж, явцыг шалгуур үзүүлэлтийн тусламжтай тайлагнаж болохоор тусгаж хэвших.

4. Арга хэмжээг дэд зорилт болгон задалж төлөвлөх. Үндсэн чиг үүргийн хүрээнд хийж буй томоохон чиг үүргүүдийн хүрээнд нэг арга хэмжээг дотор нь задалж дэд түвшинд төлөвлөх, тус бүрийн гүйцэтгэлийг үнэлж нэгдсэн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.

5. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөх. Малгай зорилтын хүрээнд хэд хэдэн арга хэмжээ болгож хуваахдаа агуулгаар нь нэгтгэх.

6. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, тооцоо судалгаанд үндэслэсэн баримтад тулгуурлан гаргаж хэвших;

7. Ямар эерэг үр дүнд хүрсэн талаар бодит нотолгоотой тайлан бичиж ирүүлэх;

8. 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, агуулгын хувьд тодорхой, ойлгомжтой, зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг нэгж тус бүр дотооддоо хяналт тавьж, тайлагнаж хэвших;

9. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ахиулахтай холбоотой нэгжийн удирдлагууд хяналт тавьж ажиллах; /

10. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотооддоо хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийн хамт яаманд ирүүлж байх.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.